

Дархан-Уул аймгийн Дархан сумын шалгалтын товч тайланг

Хорооны даргын А/161 тоот тушаалын дагуу Телевиз радиогийн өргөн нэвтрүүлэг, үүрэн холбоо, интернетийн үйлчилгээ эрхлэгч болон радио давтамж ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудад “Харилцаа холбооны тухай”, “Радио долгионы тухай”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” болон тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчдийн гэрээний хэрэгжилт болон радио давтамжийн ашиглалтын байдалд хэмжилт шалгалт хийх, зөрчлийг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас ирүүлсэн албан тоотын дагуу хэмжилт шалгалт хийж зөрчлийг арилгах зорилгоор 2014 оны 9 дүгээр сарын 15-наас 2014 оны 9 дүгээр 29-ний өдрүүдэд инженер Ц. Өсөхбаяр, Ц. Батхүү жолооч Т. Цэдэндамба нар Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл аймгуудад Сэлэнгэ аймгийн Мандал сум, Төв аймгийн Заамар суманд ажиллаа.

Шалгалтанд нийт 21 үйлчилгээ эрхлэгч хамрагдсанаас тусгай зөвшөөрлийн дагуу радио давтамжийг ашиглан үйл үйлчилгээ явуулж байгаа нь телевизийн өргөн нэвтрүүлгийн 2, Утасгүй агаарын олон сувгийн телевизийн үйлчилгээ эрхлэх 3, радио өргөн нэвтрүүлгийн 5, ISP утасгүй интернэт үйлчилгээ үзүүлэгч 0, нийт 10 тусгай зөвшөөрөл эзэмшигчид байсан. Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд үйл ажиллагаагаа явуулаагүй байсан болно.

Радио өргөн нэвтрүүлэг

Ауразон ХХК Радио ФМ-89.9, Дархан мэдээлэл төв ХХК Радио ФМ-102.5 Радио Телевизийн Сүлжээ УТҮГ ФМ-105.5 Хос дог ХХК Бизнес Радио ФМ-106.5 Лха ХХК-ийн “Лха Хөх Тэнгэр Радио ФМ-107.5” гэх эдгээр газрууд радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаагаа явуулж байлаа. Ауразон ХХК Радио ФМ-89.9-ийн хувьд төхөөрөмжийн марк болон техникийн үзүүлэлт өөрчлөгдсөн, Дархан мэдээлэл төв ХХК Радио ФМ-102.5-ийн үндсэн нэвтрүүлэгч эвдэрсэн, өөр нэвтрүүлэгч сольж тавьсан тухайгаа ХХЗХ-д мэдэгдээгүй, “Лха Хөх Тэнгэр Радио ФМ-107.5”-ын нэвтрүүлэх станцыг гаралтын чадал тусгай зөвшөөрөлд заасан үзүүлэлтээс бага байсан зэрэг дутагдлууд илэрсэн болно. Радио Телевизийн Сүлжээ УТҮГ ФМ-105.5-ын хувьд үйл ажиллагаа хэвийн сайн явагдаж байлаа. Шинэ Монгол Долгион ХХК ФМ-99.1, Мотесн ХХК ФМ-99.9, Салхи Энтертэйнмэнт ФМ-104.5, Аа Жи Би Ти Виз ХХК ФМ-105, Аббо ХХК ФМ-107.1 эдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд үйл ажиллагаагаа явуулаагүй, техник тоног төхөөрөмж гэмтэж эвдэрсэн эсвэл үйл ажиллагаа явуулах техникийн нөхцөл бололцоо нь хангагдаагүй байлаа.

Телевизийн өргөн нэвтрүүлэг

Аа Жи Би ХХК “RGB” телевиз, ЛХА ХХК-ийн “ЛХА ТЕЛЕВИЗ”, Дархан мэдээлэл төв ХХК “DBS” телевиз, Сатурн Комплекс ХХК “TV12” телевиз, Мотесн ХХК, РТС УТҮГ Олон сувгийн телевиз гэсэн телевизийн өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа явуулж буй байгууллага, компаниудаас ЛХА ХХК-ийн “ЛХА ТЕЛЕВИЗ”, Сатурн Комплекс ХХК “TV12 телевизүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Аа Жи Би ХХК “RGB” телевиз, Дархан мэдээлэл төв ХХК “DBS” телевиз, Мотесн ХХК нар өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа явуулаагүй байсан болно. РТС УТҮГ Олон сувгийн телевиз нь телевизийн 39, 43, 47, 49, 52, 54-р сувгийн модулятор дээр тохируулан 6 сувгаар телевизийн нэвтрүүлэг цацан, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байлаа.

Телевизийн олон сувгийг дамжуулах MMDS үйлчилгээ

Лха хөх тэнгэр ХХК-ийн “Лха КаТВ”, Сатурн комплекс ХХК-ийн “САТУРН КаТВ”, ДиБиЭс ХХК-ийн “DBS”КаТВ гэх компаниуд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байсан бөгөөд Лха

хөх тэнгэр ХХК-ийн хувьд шинэ нэвтрүүлэх станцаа ДиБиЭс ХХК-ийн “DBS”КаТВ-ийн тусгай зөвшөөрөлтэй давтамж дээр туршилт хийн “DBS”КаТВ-ийн үйл ажиллагаанд саад учруулсан тогтоогдсон бөгөөд хяналт шалгалтын явцад тухайн туршилт хийсэн давтамж дээрх “Лха КаТВ”-ийн тоног төхөөрөмжийг буулгаж арга хэмжээ авсан болно.

Утасгүй интернэтийн WIFI-ийн хэмжилт

Тус суманд Ийзи нет ХХК, Тэнгэрийн ауруг ХХК гэх тусгай зөвшөөрөлтэй компаниуд байгаа боловч үйл ажиллагаа явуулаагүй байсан болно.

Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдэд хийсэн хэмжилт

Үүрэн холбооны Мобиком корпораци ХХК, Юнител групп ХХК, Скайтел ХХК, Жи-Мобайл ХХК оператор компаниудын тусгай зөвшөөрлийн радио давтамжуудад гадны харилцан нөлөөлөл илрээгүй бөгөөд давтамж ашиглалт хэвийн байв.

ДҮГНЭЛТ

Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл аймгуудад Телевиз радиогийн өргөн нэвтрүүлэг, үүрэн холбоо, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон радио давтамж ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудад “Харилцаа холбооны тухай”, “Радио долгионы тухай”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” болон тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчдийн гэрээний хэрэгжилт болон радио давтамжийн ашиглалтын байдалд хэмжилт шалгалт хийх явцад тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, компаниудын нийтлэг зөрчил гаргаж байгаа нь нэвтрүүлэх станцыг стандартын дагуу газардуулага хийгдээгүй байлаа. Мөн үйл ажиллагаа явуулаагүй, нэвтрүүлэх станцын тоног төхөөрөмж гэмтэж эвдэрсэн талаар ХХЗХ-нд албан бичгээр мэдэгдээгүй, нэвтрүүлэгчийн гаралтын чадал тусгай зөвшөөрөлд заасан техникийн үзүүлэлтээс бага байгаа, техник тоног төхөөрөмжийн марк өөрчлөгдсөн зэрэг зөрчил дутагдлууд илэрч байсан болно. Иймд тус хороонд үйл ажиллагаагаа тур хугацаагаар зогсоосон талаар мэдэгдэх, тусгай зөвшөөрлийн техник, тоног төхөөрөмж болон нэвтрүүлэх станцын гаралтын чадлыг техникийн үзүүлэлт зэрэг мэдээлэлд “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын дагуу тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах талаар хүсэлтээ уг журамд заасны дагуу ирүүлэх шаардлагатай байна.